



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2018.12.28 № 515344
танай _____-ны № _____-т

**АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗАР, ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДАД**

Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/461 тоот тушаалыг хавсралтаар хүргүүлж байна.

Нийтээр тэмдэглэх баярын өдөр болох Шинэ жилийн баяраар 2018 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрүүдэд ажиллах хариуцлагатай жижүүрийг томилон, дээрхи тушаалыг мөрдлөг болгон ажиллана уу.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА  Б.ЦОГТБАТАР



085462



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А/461

Улаанбаатар хот

Хариуцлагатай жижүүр томилох тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 76 дугаар зүйлийн 76.1.1, Яамны хөдөлмөрийн дотоод журмын 5.15 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийтээр тэмдэглэх баярын өдөр болох Шинэ жилийн баяраар 2018 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрүүдэд ажиллах хариуцлагатай жижүүр хийх албан хаагчдын хуваарийг нэгдүгээр, ажлын удирдамжийг хоёрдугаар, эрүүл мэндийн байгууллагуудаас мэдээлэл авах хүснэгтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Улсын хэмжээнд эрүүл мэндийн байгууллагуудтай цахим хурал хийж, бэлэн байдлыг ханган ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /М.Баттүвшин/т үүрэг болгосугай.

3. Яамны 11-323002 утсанд ирсэн санал хүсэлтийг хүлээн авч, холбогдох газар, хэлтсийн дарга болон удирдлагуудад мэдээ эгч удирдамжийн дагуу ажиллахыг хариуцлагатай жижүүр хийж, үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдад үүрэг болгосугай.

4. Хариуцлагатай жижүүрээр ажилласан албан хаагчдыг хууль тогтоомж, журамд заасны дагуу нөхөн амруулж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Цогтбаатар/-т даалгасугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Э.СОДНОМЖАМЦ



081339

Төрийн нарийн бичгийн даргын
2018 оны 12 сарын 28 өдрийн
А/461 дугаар тушаалын нэг дүгээр хавсралт



**ШИНЭ ЖИЛИЙН БАЯРЫН ӨДРҮҮДЭД АЖИЛЛАХ
ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН ХУВААРЬ**

№	Ажиллах цаг	Хариуцлагатай жижүүр хийх албан хаагчдын нэрс	Газар, хэлтэс	Хяналт тавих албан тушаалтан
2018 оны 12 дугаар сарын 29-ний өдөр				
1	08.00-20.00	Ц.Хандармаа	НЭМГ	Т.Энхзаяа
2	21.00-08.00	Г.Бат-Эрдэнэ	ХОХ	
2018 оны 12 дугаар сарын 30-ны өдөр				
1	08.00-20.00	Б.Уянга	ЭТЧАБХ	Г.Ганхуяг
2	21.00-08.00	Н.Гэрэлт-Од	ЭҮТГ	
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр				
1	08.00-20.00	Т.Болорчимэг	ХШУДАГ	Я.Амаржаргал
2	21.00-08.00	Ч.Түвшинтөр	ОНХТШУХ	
2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдөр				
1	08.00-20.00	Д.Ганзориг	БТГ	Б.Цогтбаатар
2	21.00-08.00	Г.Базархүрэл	ХОХ	

Төрийн нарийн бичгийн даргын
2018 оны 12 сарын 28 өдрийн
А/461 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Нийтлэг зүйл.

Улирлын томуугийн үе, байгалийн болон хүний буруутай үйл ажиллагаатай холбоотой гамшиг, осол, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, өвөлжилтийн бэлэн байдалд анхаарч ажиллах, гарч болзошгүй хүндрэл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, хяналтыг сайжруулах болон нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд бэлэн байдлыг ханган ажиллах.

1. Хугацаа:

- 2018 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 08.00 цагаас
- 2019 оны 01 дүгээр сарын 02-ны 08.00 цаг хүртэл

2. Жижүүрийн ажиллах цаг:

Тухайн өдрийн:

- Өглөөний 08.00 цагаас тухайн өдрийн оройн 20.00
- 20.00-цагаас маргааш өглөөний нь 08.00 цаг

3. Зорилго: Эрүүл мэндийн салбарын хариуцлага, хяналтыг сайжруулах

4. Зорилт:

- 4.1. Эх, хүүхдийн төрөлт, нас баралт,
- 4.2. Томуу, томуу төст өвчлөл,
- 4.3. Халдварт өвчин,
- 4.4. Гэнэтийн осол гэмтэл, цас, зуд, шуурга, олныг хамарсан өвчлөл, хордлого, эндэгдлийн байдалд хяналт тавьж, салбарын хэмжээний мэдээ гаргаж, мэдээлэх, нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд бэлэн байдлыг ханган ажиллах.

5. Эрүүл мэндийн яаман дээр мэдээ хүлээж авах утасны дугаар: 11- 323002

5.1. Жижүүрийн үйл ажиллагаа:

5.1.1. ЭМЯ-ны 11-323002 утсанд ирсэн мэдээ, санал хүсэлтийг хүлээн авч, зохицуулалт хийх, газар, хэлтсийн дарга нарт танилцуулж, шийдвэрлэх арга хэмжээ авах,

5.1.2. Эрүүл мэндийн байгууллагуудаас өдөрт 2 удаа мэдээ авах буюу:

- 08.00-20.00 цагийн мэдээг оройны 21.00 цагт,
- 20.00-08.00 цагийн мэдээг 07.00 цагт тушаалын гуравдугаар хавсралтад заасан хүснэгтийн дагуу авч нэгтгэн гарын үсгээр баталгаажуулан, хэвлэж тайланд нэгтгэн хавсаргана.

5.1.3. Эрүүл мэндийн байгууллага дээр гарч байгаа хариуцлагатай жижүүр ирүүлж байгаа мэдээний үнэн зөвийг хариуцаж ажиллана.

5.1.4. Эрүүл мэндийн байгууллагууд хариуцлагатай жижүүрийн нэрс, утасны дугаарыг урьдчилан ирүүлсэн байна.

5.1.5. Хариуцлагатай жижүүр, гамшиг осол, НЭМ-ийн ноцтой байдал үүссэн үед тухай бүрт мэдээг авч, шаардлагатай үед нэмэлт бүртгэл, тайлан, тайлбар мэдээг хөтлөнө.

5.1.6. Эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн мэдээллийг цаг минутын хамт бүртгэн авч, тэмдэглэнэ.

5.1.7. Шаардлагатай тохиолдолд газар, хэлтсийн дарга, Төрийн нарийн бичгийн дарга, Дэд сайд, сайдад мэдээлэл өгч, шийдвэрлүүлнэ.

5.1.8. Ажлын зайлшгүй шаардлагаар холбогдох мэргэжилтнийг дуудах, аппаратыг бүрэн бүрэлдэхүүнээр яаралтай цуглуулах шаардлагатай гэж үзвэл, удирдлагад танилцуулан шийдвэр авч, шуурхай зохион байгуулах,

5.1.9. Нийтийг хамарсан ноцтой тохиолдлын шалтгаан болон нас баралт бүртгэгдсэн үед тухайн хүний нэр, нас, хүйс, хаяг, оношийн талаар тодорхой мэдээлэл авч, бүртгэнэ.

5.1.10. Эх, хүүхдийн эндэгдэл гарсан тохиолдолд холбогдох мэдээллийг дэлгэрэнгүй авч бүртгэн, Эмнэлгийн тусламжийн газрын дарга болон удирдлагуудад мэдээлнэ.

5.1.11. Шаардлагатай үед Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Снцгой байдлын ерөнхий газартай холбогдон мэдээ, мэдээллийг солилцож, тэмдэглэл хөтлөнө.

6. Үр дүнг тооцох:

6.1. Хариуцлагатай жижүүр үйл явцын тайлан бичиж, даргагийн жижүүрт хүлээлгэн өгнө.

6.2. Сүүлийн өдөр буух хариуцлагатай жижүүр нэгдсэн тайлан бичиж, Төрийн нарийн бичгийн дарга болон Төрийн захиргааны удирдлагын газрын даргад танилцуулж, хүлээлгэн өгнө.

Төрийн нарийн бичгийн даргын
2018 оны... сарын... өдрийн
#4.61 дугаар тушаалын гуравдугаар хэвсрэлт

ШИНЭ ЖИЛИЙН БААРЫН ӨДӨР ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖГҮҮРИЙН
МЭДЭЭЛЭЛ АВАХ ХҮСНЭГТ /өдөр бүрээр/



1. Эх, хүүхдийн мэдээ

Огноо:

№	Мэдээ огноо, цаг/байгууллагауд	авсан	ЭХЭМҮТ	НЭМГ	Архангай	Баянхонгор	Булган	Баян-Өлгий	Говь-Алтай	Говьсүмбэр	Дархан-Уул	Дорнод	Дорноговь	Дундговь	Завхан	Орхон	Өмнөговь	Өвөрхангай	Сэлэнгэ	Сүхбаатар	Төв	Увс	Хэнтий	Ховд	Хөвсгөл	НИЙТ	
1	Нийт эхийн тоо, үүнээс:	төрсөн																									
2	Гэртээ эхийн тоо	төрсөн																									
3	Амьд хүүхдийн үүнээс:	төрсөн тоо,																									
4	Хүү																										
5	Охин																										
6	Бусад																										
7	Тухайн өгсөн	мэдээл мэргэжилтний нэр																									
8	Мэдээг авсан	хүлээж авсан																									
	Мэргэжилтний нэр																										

Жич: Нийслэлд, НЭМГ нийслэлийн хэмжээний мэдээг нэгтгэн өгөхдөө амаржих газар тус бүрээр гаргаж өгнө.

13	Отор нүүдлээр яваа иргэд дотор жирэмсэн эхийн тоо																			
14	Отор нүүдлээр яваа иргэд дотор 5 хүртэлх насны хүүхдийн тоо																			
16	Бусад																			
17	Тухайн мэдээг өгсөн мэргэжилтний нэр																			
18	Мэдээг хүлээж авсан мэргэжилтний нэр																			

Тайлбар:

1. Мэдээг 24 цагаар өгөх ба олон хүнийг хамарсан хордлого, осол гэмтэл, ноцтой хүндрэл, эхийн эндэгдэл гарсан тохиолдолд хугацаа харгалзахгүй удирдах шатанд шуурхай мэдээлнэ.
2. Нийтийг хамарсан ноцтой тохиолдлын шалтгаан болон нас баралт бүртгэгдсэн үед тухайн хүний нэр, нас, хүйс, хаяг, оношийг тусад нь нэмэлт тайлан, мэдээ бичиж нэгтгэнэ.